



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 1/АЧУ

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Залуус хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил"-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Очбадрах ("Мандалын гэгээ хот тохижуулах газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга)

Гишүүд:

Э.Эрдэнэжаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчилгээний албаны дарга)

Э.Дүүрэнжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

И.Эрдэнэцог (Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Нарийн бичиг:

Б.Сайхантуяа (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Д.Очбадрах)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сайхантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4802100607